

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709  
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ  
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.01.31

### Онцлох мэдээ

- Ковид-19 цар тахлын тохиолдлууд болон хөл хоригууд эрэлт нийлүүлэлтэд дарамт болсон хэвээр, улмаар Хятадын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 1-р сард саарчээ. PMI индекс 50.1 буюу өсөлттэй түвшинд гарсан хэдий ч 12-р сарын 50.3 нэгжээс буурсан байна.
- Япон улсын үйлдвэрлэлийн гарц 12-р сард сүүлийн гурван сарын хугацаанд анх удаа агшсан бөгөөд машин механизмын бууралт автомашины салбарын багахан өсөлтөд голчлон нөлөөлөв. 12-р сард Японы үйлдвэрлэлийн гарц нь 1.0% буурчээ.

### Валютын зах зээл

Арилжаачид Австрали, Их Британи болон Европын төв банкнуудын хурлыг хүлээх зуур хөрөнгийн захын хэлбэлзэл богино хугацаанд өсөх төлөвтэй байгаа шалтгаанаар ам.доллар еврогийн эсрэг нэг жил хагасын дээд цэгт хүрэв. Еврогийн ханш Баасан гарагийн доод 1.1119 хашннаас бага зэрэг өндийж 1.1148-тай тэнцүү байна. Австрали доллар мөн адил Баасан гарагт тогтоогоод байсан 18 сарын доод цэг орчимд суларч 0.6991-р арилжаалагдаж байна. Фунт 1.34014 буюу өнгөрсөн долоо хоногийн 1 сарын доод түвшинд ойролцоо хэлбэлзэж байна.

ОХУ-ын рубль өнгөрсөн Баасан гарагийн бас нэгэн савлагаа ихтэй арилжаагаар суларсан хэдий ч Украин улсын талаарх болгоомжлолыг Москвагаас намжаах гэж оролдсоноор өмнөх арилжааны ихэнх өсөлтөө авч үлджээ. Тус өдрийн 23:55 цагийн байдлаар рубль 0.2% буурч 78.14 хүрсэн юм.

### Алтны зах зээл

Даваа гарагт алтны ханш 4 дэх арилжааны өдрөө дараалан унаад байна. Төв банкны чухал хурлын өмнө ам.доллар чангараад байгаа бөгөөд ингэснээр алтны ханш 9 сараас хойших хамгийн өндөр сарын уналт үзүүлэх гэж байна. 1 унц алтны спот ханш өглөөний байдлаар 12 сарын 16-наас хойших доод цэг өмнөх арилжааны өдрийн 1,779.20 гэсэн ханштай ойр байгаа бөгөөд 0.2% бууралттай 1,788.41 ам.доллартай тэнцүү байна. АНУ-ын алтны фьючерс GCv1 0.1% дээшилж 1,788.20 ам.доллар байна. Энэ сард металлын ханш 2 гаруй хувь унаад байна.

### Зэсийн зах зээл

Даваа гарагийн арилжааны эхэн үед зэсийн ханш өмнөх арилжаагаар хүрээд байсан 3 долоо хоногийн доод түвшнээс эргэн өслөө. Гэвч сарын байдлаар алдагдал хүлээхээр болов. Лондонгийн Металлын Биржийн 3 сарын хугацаатай зэсийн фьючерсийн үнэ 0.7% ахиж тонн нь 9,575 ам.доллараар арилжаалагдаж байна. Баасан гарагт ханш 9,496 ам.доллар буюу 3 долоо хоногийн доод цэгт хүрсэн ба 1-р сард 1 гаруй хувь унаад байгаа юм. Цагаан сарын баярын амралттай холбоотойгоор Шанхайн

Валют	Ханш	24ц өөрч.		
EUR/USD	1.1163	0.11%		
USD/CNY	6.3716	0.07%		
USD/RUB	77.8662	0.07%		
USD/JPY	115.51	0.22%		
USD/KRW	1205.9	0.28%		
AUD/USD	0.7008	0.04%		
GBP/USD	1.3411	0.00%		
Индекс	Нэгж	24ц өөрч.		
Dow Jones	34725.5	1.65%		
S&P 500	4431.9	2.43%		
NASDAQ	13770.6	3.13%		
FTSE 100	7466.1	-1.17%		
Nikkei 225	27094.7	1.41%		
DAX	15319.0	-1.32%		
Hang Seng	23927.9	1.60%		
Метал	Ханш (USD)	24ц өөрч.		
Алт	1786.81	-0.26%		
Мөнгө	22.28	-0.84%		
Нүүрс (Чин хуанг дао)	153.34	0.00%		
Зэс (LME)	9507.5	-2.81%		
Төмрийн хүдэр	797.50	3.50%		
Газрын тос (NYME)	87.85	1.19%		
LIBOR	Хүү	24ц өөрч.		
US 1M LIBOR	0.11%	1.23%		
US 3M LIBOR	0.32%	5.88%		
US 6M LIBOR	0.53%	3.03%		
US 12M LIBOR	0.95%	2.85%		
Бонд	Хүү	24ц өөрч.		
US Treasury 10Y	1.79%	1.21%		
UK Treasury 10Y	1.24%	1.30%		
GE Treasury 10Y	-0.05%	23.73%		
JP Treasury 10Y	0.18%	2.34%		
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
МИК 2022	9.75%	1/29/2022	11.19%	-0.18%
Чингис	5.13%	12/5/2022	3.06%	0.00%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.71%	-0.05%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.21%	-0.18%
Хуралдай	8.75%	3/9/2024	3.99%	-0.09%
ММС	9.25%	4/15/2024	22.08%	0.20%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.19%	-0.18%
Номад	5.13%	4/7/2026	4.70%	-0.10%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.84%	-0.03%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.31%	-0.03%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.03%	0.00%

Хувьцаа	Ханш	24ц өөрч.
Turquoise Hill Resources	17.64	-4.13%
Mongolian Mining Corp	1.46	-6.41%
Erdene Resource Dev	0.40	-1.25%
Centerra Gold	10.17	0.20%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2021 (XII)	13.4%
Бодлогын хүү	2021 (XII)	6.0%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XI)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2021 (XII)	7.04%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2021 (XII)	2.04%
Зээлийн дундаж хүү (төг)	2021 (XII)	15.54%
Зээлийн дундаж хүү (валют)	2021 (XII)	9.07%

Ханшийн таамаглал					
Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.15	1.17
GBP/USD	1.34	1.35	1.36	1.37	1.40
USD/CNH	6.39	6.35	6.40	6.44	6.40
USD/JPY	114	115	115	115	115
USD/RUB	73.0	72.0	73.07	73.0	73.5

Түүхий эд					
Алт	1775	1750	1700	1680	1650
Зэс	9500	9350	9400	9500	9550
Нүүрс	138.13	109.38	93.13	79.38	62.50

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
FR GDP Preliminary QQ	0.7%	0.5%	3.0%
GE GDP Flash QQ SA	-0.7%	-0.3%	1.7%
JP CPI, Overall Tokyo	0.5%	-	0.8%
US Consumption, Adjusted MM	-0.6%	-0.6%	0.6%

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
GE HICP Prelim YY	21:00	4.7%	5.7%
GE CPI Prelim YY	21:00	4.3%	5.3%
JP Industrial O/P Prelim MM	7:50	-0.8%	7.0%
EU GDP Flash Prelim QQ	18:00	0.3%	2.2%

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
JP Unemployment Rate	7:30	2.8%	2.8%
GE Unemployment Rate	16:15	5.2%	5.2%
GE Markit/BME Mfg PMI	16:30	60.5	60.5
JP Jibun Bank Mfg PMI	8:30	-	54.6
US ISM Manufacturing PMI	23:00	57.5	58.7

Фьючерсийн Бирж 02.07-ны өдрийг хүртэл хаалттай байна.

## Газрын тосны зах зээл

Зүүн Европ болон Ойрхи Дорнодын улс төрийн маргаан мөн хангалтгүй нийлүүлэлтээс шалтгаалж газрын тосны үнэ сүүлийн 7 жилийн хамгийн өндөр түвшинд хүрээд байна. Brent газрын тосны үнэ 1 хувь өсөж 90.95 орчим ам.долларт арилжаалагдаж байна. ОХУ болон барууны Украйны талаарх үүсээд байгаа маргаан Европт газрын тосны хомсдол үүсгэх эрсдэл мөн үнэ өсөхөд нөлөөлж байна.

## Бондын зах зээл

АНУ-ын засгийн бондын фьючерс 2 хоног өссөний дараа Азийн захын нээлтээр уналаа. 10 жилийн хугацаатай фьючерс нь 5/32 унаж 127 27/32 боллоо. Австралийн засгийн бонд Мягмар гарагт болох Төв банкны хурлаас өмнө үргэлжлүүлэн өссөөр байна. АНУ-ын Холбооны Нөөцийн банк тахлын үеийн дэмжлэгүүдээ эргүүлэн татаж эхэлснээр Дэлхийн хамгийн том бондын зах дээр тогтворгүй байдал хүлээгдэж байгаа гэсэн хандлага нэмэгдсээр байна.

## Хөрөнгийн зах зээл

Дэлхийн хамгийн том уламжлалт бус хөрөнгө оруулалтын сан Blackstone 11 тэрбум ам.долларыг Азийн компаниудыг худалдан авахаар бэлтгэсэн байна. 2018 онд тус сангийн ижил чиглэлээр босгосон хөрөнгө оруулалтаас 3 дахин их дүнтэй хөрөнгө оруулалт болохоор байна. Blackstone сан Азийн компаниудыг худалдаж авахад 2018 оноос хойш 20 тэрбум ам.долларыг зарцуулаад байна.

### Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мэйлд харуу илгээнэ үү.